



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 310

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Барилгын политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй сэргээн засварлах боломжгүй болсон нийт 2,822,400.00 (хоёр сая найман зуун хорин хоёр мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ, 1,450,400.00 (нэг сая дөрвөн зуун тавин мянга дөрвөн зуун) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг агуулахын барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Барилгын политехник коллежийн захирал Г.Нямдуламд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

2.4.Үл хөдлөх хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 06 дугаар сарын 26 -ны өдрийн
 810 дугаар тогтоолын хавсралт

Барилгын политехник коллежийн үндсэн
 хөрөнгөд бүртгэлтэй актлах барилгын жатсаалт

Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1 Агуулах-2	2000	Баянгол дүүрэг, 15 дугаар хороо, аж ахуйн аргаар барьсан, 1 давхар, 54м2	2,822,400.00	1,450,400.00	1,372,000.00
Нийт дүн			2,822,400.00 (хоёр сая найман зуун хорин хоёр мянга дөрвөн зуун)	1,450,400.00 (нэг сая дөрвөн зуун тавин мянга дөрвөн зуун)	1,372,000.00 (нэг сая гурван зуун далан хоёр мянган)

Д/д